

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ГААЛИЙН ХОРООНЫ 2019-2020 ОН, 2021 ОНЫ 1-2 ДУГААР САРУУДЫН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2021 он

Есөнбулаг сум

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2021 оны 03 сарын 24 өдөр Дугаар 05 . Алтай хот

Санхүүгийн хяналт шалгалт
хийсэн дүнгийн тухай.

НЭГ: ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО.

Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 01 дүгээр нэгдсэн удирдамжийн дагуу Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2019, 2020, 2021 оны эхний 2 сарын санхүүгийн үйл ажиллагаа нь "Төсвийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Гаалийн тухай" хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудтай нийцэж байгаа эсэхийг "Төрийн хяналт шалгалтын тухай" хуулийн дагуу шалгаж, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж, засаж залруулан, зөвлөн тусалж, ирээдүйд учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд хяналт шалгалтын зорилго оршино.

ХОЁР: ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА.

Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч Ч.Дулмаа, Санхүүгийн хяналт, шалгалтын Улсын байцаагч Б.Дэлгэрбаяр нарын бүрэлдэхүүнтэйгээр 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийг дуустал ажлын 17 өдрийн хугацаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийв.

ГУРАВ: ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД.

Говь-Алтай аймаг дахь Гаалийн хорооны 2019, 2020, 2021 оны 02 дугаар сар дуустал хугацааны удирдамжид тусгасан асуудлуудыг шалгалтад бүрэн хамруулсан болно.

ДӨРӨВ: ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЬЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.

Говь-Алтай аймгийн Гаалийн хороо нь /570001131 тоот Улсын бүртгэлийн дугаартай, 9018026 регистрийн дугаартай/ Есөнбулаг сумын Харзат багийн Батсуурийн гудамжинд байрлан 19 орон тоотой удирдлагын, хяналт шалгалтын, үйлчилгээний гэсэн нэгжүүдтэй бөгөөд байгууллагын даргаар Х.Амартүвшин, Д.Эрдэнэсүх, нягтлан бодогчоор Д.Жамбалсүрэн нар ажиллаж төрийн сангийн 100050011005 тоот дансаар санхүүгийн үйл ажиллагаанд 1,2-р гарын үсэг зурж төсвийн хөрөнгийг зарцуулж иржээ.

400076

ТАВ: ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.

Аудитын байгууллагын шалгалтаар:

2019 он:

Тус байгуулагын 2019 оны санхүүгийн тайланд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж 5 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлж "Зөрчилгүй" дүгнэлт өгсөн байна. Албан шаардлагаар өгсөн үүргийг хугацаанд нь биелүүлж хариуг албан бичгээр хүргүүлжээ.

2020 он:

Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2020 оны санхүүгийн тайланд "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн байна.

Аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Цалингийн зардлаас төлөх 1443.3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлсөн.

2. Шилэн дансны цахим хуудсанд тайлант оны 6, 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийг дутуу мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 орлого, зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 1 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

Мөн байгууллагын удирдлага өөрийн хамаарал бүхий этгээдтэй албан конторын засварын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтаар:

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Говь-Алтай аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар дараах зөрчил илэрсэн байна.

1. 46444.5 мянган төгрөгийн дүн бүхий 12 удаагийн гүйлгээнд 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулаагүй.

2. Хилийн боомтын хэрэглээний болон ундны усанд өдөрт 100-аас 120-н литр шатахуун, бохирын ус зайлуулахад өдөрт 30-н литр шатахуун зарцуулсан.

3. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолыг хэрэгжүүлээгүй.

4. Эд хариуцагч тооцоот хуудасны зарцуулалтыг зохих маягтын дагуу тухай бүр хөтөлдөггүй, тайлан гаргадаггүй, зөвхөн байцаагч нарт олгосон гар тэмдэглэл хөтөлсөн.

5.Албан томилолтын олговрыг удирдамж, илтгэх хуудасгүйгээр олгосон.

6. Ажлаас чөлөөлөгдсөн ажилтан албан хаагчдын ээлжийн амралтын эцсийн тооцоо хийгдээгүй.

7. Ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилтантай эд хөрөнгийн болоод бусад тооцоог тойрох хуудсаар хийж хэвшээгүй.

8. Эд хариуцагч өөрийн эзэмшилд байгаа хөрөнгийн тайлан гаргадаггүй, тайлан гаргаж үзээгүй зөвхөн шаардах хуудас, хөрөнгийн орлогын баримт үйлдэж түүнийг үндэслэн нягтлан бодогч нягтлан бодох бүртгэл хөтөлдөг

9. Жолооч нар өөрийн авсан шатахууны хэмжээнд тааруулан жолоочийн замын хуудсыг бичсэн бөгөөд түүнийг үндэслэн нягтлан бодогч шатахууныг шууд зардал болгосон зөрчилд 9 заалт бүхий албан шаардлага хүргүүлсэн байна.

ЗУРГАА: ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДЛУУД.

- Гаалийн бүрдүүлэлт, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт.

2019 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар нийт 13326 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс экспортын 13311 гаалийн бүрдүүлэлт, импортын 15 гаалийн бүрдүүлэлт хийгдсэн байна. Үүнээс 9361 буюу 70,32 хувь нь ногоон төлөв, 3278 буюу 24.62 хувь нь улбар шар төлөв, 687 буюу 5.16 хувь нь улаан төлөвт сонгогдсон. Нийт экспортын бүрдүүлэлтийн 94,94 хувь нь бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдсөн байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт экспортын 1469 гаалийн бүрдүүлэлт хийгдсэнээс 1051 гаалийн бүрдүүлэлт буюу 71.5 хувь нь ногоон төлөв, 345 гаалийн бүрдүүлэлт буюу 23.4 хувь нь улбар шар төлөв, 74 гаалийн бүрдүүлэлт буюу 5.0 хувь нь улаан төлөв сонгогдож нийт 1396 гаалийн бүрдүүлэлт буюу 95.0 орчим хувь нь бараанд хийх шалгалтаас чөлөөлөгдсөн байна.

2020 оны тайлант хугацаанд тус боомтоор 1 горимын дагуу 1469 гаалийн бүрдүүлэлт хийгдсэн. Энэ нь 100 горимын шаардлагын дагуу хийгдсэн 100 хувь “Алтайн хүдэр” ХХК-ийн төмрийн хүдрийн баяжмалын экспортын гаалийн бүрдүүлэлт байна.

2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд цар тахалтай холбоотойгоор зарим хилийн боомтуудыг хөдөлгөөнийг хязгаарласантай холбоотой импортийн гаалийн бүрдүүлэлт байхгүй байна.

Гаалийн бүрдүүлэлтийн горимын хэрэгжилт:

Нэр, төрөл	Горим	2019 он	2020 он	Бүрдүүлэлтийн бууралт
		Бүрдүүлэлтийн тоо	Бүрдүүлэлтийн тоо	
экспорт	100	13311	1469	11842
импорт	400	15	0	15
	Нийт	13326	1469	11857

2019, 2020 онуудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан бараа, тээврийн хэрэгсэл байхгүй байна.

- Гаалийн баталгаат агуулах болон түр горимд буй бараа материалын хөдөлгөөн.

Гаалийн баталгаат агуулах, горимд байгаа бараа материалын хөдөлгөөн байхгүй.

- Төсвийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт, хуваарилалт, үр дүн.

Гаалийн хураамж, татвар:

2019 он:

Тус гаалийн хороо нь 2019 оны жилийн эцэст татварын орлогоор 55.15 сая төгрөг төвлөрүүлэхээс 2019 оны 12 сарын 30-ны өдрийн байдлаар 45.56 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөө 9.59 сая төгрөгөөр тасарч гүйцэтгэл 88.37 хувьтай байна.

2019 оны жилийн эцэст хураамжийн орлогоор 2,494.43 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,770.16 сая төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 70.16 хувьтай байна.

2019 оны жилийн эцэст өөрийн орлогоор 3.87 сая төгрөг төвлөрүүлэхээс 1.61 сая төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 41.56 хувьтай байна.

2019 онд улсын төсөвт нийт орлогоор 2,549.85 сая төгрөг төвлөрүүлэхээс 1,817.32 сая төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 71.72 хувьтай байна.

2020 он:

Тус гаалийн хороо нь Гаалийн ерөнхий газрын даргын 2020 оны 11-р сарын 02-ний өдрийн А/205 дугаарт тушаалаар улсын төсөвт нийт өссөн дүнгээрээ 536.17 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсан.

Үүнээс :

1. Татварын орлогоор –91.77 сая төгрөг,
2. Хураамжийн орлогоор – 443.54 сая төгрөг,
3. Өөрийн орлогоор – 0.86 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй ажилласан байна.

2020 оны эхнээс өссөн дүнгээр 91.77 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэй боловч гаалийн импортын нэг ч бүрдүүлэлт хийгдээгүй улсын төсөвт татварын орлогоор ямар ч орлого төвлөрүүлээгүй байна.

Хураамжийн орлогын төлөвлөгөөгөөр 2020 оны эхнээс өссөн дүнгээр 443.56 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэхээс 2020 оны 12 сарын 30-ны өдрийн байдлаар 140.00 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 31.56 хувьтай байна. Өөрийн орлогын төлөвлөгөөгөөр 2020 оны эхнээс өссөн дүнгээр 0.86 сая төгрөг төвлөрүүлэхээс 2020.12.30-ны өдрийн байдлаар 0.60 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт 69.77 % байна.

2020 оны жилийн эцэст нийт төсвийн орлогоор 536.19 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 2020 оны 12-р сарын 30-ны өдрийн байдлаар 140.60 сая төгрөг төвлөрүүлж улсын төсвийн орлого нийт дүнгээрээ 26.22 хувийн гүйцэтгэлтэй байна.

2021 он:

ГЕГ-н даргын 2021 оны 01 сарын 21 өдрийн А/04- " Улсын төсвийн гаалийн орлогын сар, улирлын хуваарь батлах тухай"- тушаалаар тус гаалийн хороо нь 2021 онд улсын төсөвт нийт 1,597.31 сая төгрөг төвлөрүүлэхээр батлагдсан.

Үүнээс :

1. Татварын орлогоор – 26.45 сая төгрөг
2. Хураамжийн орлогоор – 1,567.46 сая төгрөг
3. Өөрийн орлогоор – 3.40 сая төгрөг төвлөрүүлэхээр тус тус батлагдсан.

2021 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн байдлаар боомт ажиллаагүй тул төсвийн орлогын бүрдүүлэлт хийгдээгүй байна.

Төсвийн орлого бүрдүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

/ Сая төг/

Нэр, төрөл	2019 он			2020 он			2021 он		
	Төл.	Гүйц.	Хувь	Төл.	Гүйц.	Хувь	Төл.	Гүйц	Хувь
Татвар	51.55	45.56	88.37	91.77	0.0	0.0	26.45	0	0
Хураамж	2494.43	1770.16	70.16	443.54	140.0	31.6	1,567.46	0	0
Өөрийн орлого	3.87	1.61	41.56	0.86	0.6	69.7	3.40	0	0
Нийт орлого	**2,549.85**	**1,817.32**	**71.72**	**536.19**	**140.60**	**26.2**	**1,597.31**	**0**	**0**

Санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэлт, зарцуулалт:

2019 он:

Улсын төсвөөс 405654.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 200986.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн 30179.8 мянган төгрөгийн байр ашиглалттай холбоотойгоор 79594.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 14613.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 65950.0 мянган төгрөг, томилолт зочны зардалд 1797.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 5331.9 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 7200.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2020 он:

Улсын төсвөөс 565037.4 мянган төгрөг төвлөрүүлж, цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 257545.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн 33814.7 мянган төгрөгийн байр ашиглалттай холбоотойгоор 175904.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 16491.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 52450.1 мянган төгрөг, томилолт зочны зардалд 1670.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 22694.0 мянган төгрөг зарцуулж, биет бус хөрөнгийн

зардалд 1587.6 мянган төгрөгийг зарцуулж улсын төсөвт 2879,4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

- Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд тусгасан эсэх.

Тус гаалийн хороо нь 2020 онд харилцагч Петроплас ХХК руу 4 удаагийн гүйлгээгээр нийт 116370.1 мянган төгрөг шилжүүлсэн байна. Үүнээс 2020 онд худалдан авсан 15905.1 мянган төгрөгийн түлшний үнийг хасвал, үлдэгдэл 100465.0 мянган төгрөгөөр 2016-2019 онд генератор ажиллуулахад хэрэглэсэн түлшний өр төлбөрийг барагдуулсан байна. Тус 100465.0 мянган төгрөгийн өр төлбөрийг Гаалийн ерөнхий газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, "Алтайн хүдэр" ХХК, "Петроплас" ХХК хоорондын тооцоо нийлсэн акт, шийдвэрээр баталгаажуулсан бөгөөд 2016-2019 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй болно.

- Өмнө хийгдсэн шалгалтууд, төлбөр зөрчил, түүний барагдуулалт.

Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, Говь-Алтай аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны 2016, 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хяналт, шалгалтаар илэрсэн зөрчилд 3 заалт бүхий албан шаардлага хүргүүлж, шийдвэрийн биелэлтийг хуулийн хугацаанд ирүүлсэн боловч зарим зөрчил тус шалгалтаар давтан илэрч байна.

- Санхүүгийн үйл ажиллагааны явц, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг бүртгэлд тусгасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт.

2021 оны 03 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд тус гаалийн хорооны Бургастай дахь шалган нэвтрүүлэх боомт, аймгийн төвд байрлах конторын үндсэн хөрөнгөд тооллого хийв.

Тус гаалийн хороо нь 2019, 2020 онд бэлтгэсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан боловч хөрөнгийг бүртгэлжүүлж, кодлоогүй, мөн ашиглалтын хугацаа дууссан, үлдэх өртөггүй, цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгүүдийг данс бүртгэлээс хассан боловч үргэлжлүүлэн ашиглаж байгаа бүртгэлгүй хөрөнгө их байлаа.

- Иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай хийсэн гэрээ, түүний хэрэгжилт.

2019 он:

Түрээсийн гэрээ:

1. 2019 оны 10 дугаар сараас эхлэн "Алтайн Билэг" ширээний теннисний холбоонд 117 метр квд талбай бүхий нэг өрөөг ямар нэгэн гэрээ, төлбөргүйгээр ашиглуулж байгаад 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгууллагын дарга Д.Эрдэнэсүх тус холбооны тэргүүн Д.Амгалан нар "Хамтран ажиллах гэрээ" байгуулсан байна.

Түрээслэгч тал түрээслүүлэгчид ямар нэгэн түрээсийн төлбөр төлөхгүйгээр үйл ажиллагаа явуулахаар гэрээ хийжээ.

2020 он:

2020 онд 2 иргэн, 4 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан нийт 45600.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан Гаалийн хорооны конторын барилга, Бургастай боомт дахь ахуйн байранд урсгал засвар хийжээ. Гэрээ тус бүрээр дэлгэрэнгүй бичив.

2. Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны дарга Д.Эрдэнэсүх, "Чин-Энх сайхан" ХХК-ийн захирал Н.Начинбаатар нарын 2020 оны 07 дугаар сарын 24-ний өдөр байгуулсан 04/2020/ дугаартай ажил гүйцэтгэх гэрээнд Говь-Алтай аймгийн Гаалийн хорооны Цагаан байшинтад байрлах 24 өрөө гаалийн ажилтнуудын ахуйн байрыг төвийн эрчим хүчинд холбогдоход шаардлагатай цахилгааны монтаж хийж тоолууржуулах ажлыг 9 800.0 мянган төгрөгөөр, 30 хоногийн дотор хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

3. Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны дарга Д.Эрдэнэсүх, "Ханбуурал" ХХК-ийн захирал Д.Алтай нарын 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан 03/2020 дугаартай ажил гүйцэтгэх гэрээнд Говь-Алтай аймгийн төвд байрлах Гаалийн хорооны ариун цэврийн өрөөний засвар, сантехникийн болон бохирын холболтуудыг хийж гүйцэтгэх ажлыг 9500.0 мянган төгрөгөөр, 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхээр тусгасан байна. Тус гэрээтэй холбогдох зөрчлийг 2020 оны санхүүгийн тайлангийн аудитад онцгойлон авч үзэж холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байгааг шалгалтын танилцуулгын 5 дахь хэсэгт тусгасан болно.

4. Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны дарга Д.Эрдэнэсүх, иргэн Х.Жаргалсайхан нарын 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан 02/2020 дугаартай ажил гүйцэтгэх гэрээнд Говь-Алтай аймгийн төвд байрлах Гаалийн хорооны дээд давхрын барилгын нийт 4 өрөөнд засвар хийх ажлыг 5500.0 мянган төгрөгөөр, 7 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхээр тусгасан боловч ажил хүлээн авах комиссын акт, дүгнэлтгүйгээр 2020 оны 08 дугаар сарын 14-ны өдөр ХХОАТ-ын 10 хувь суутган 4950.0 мянган төгрөгийг иргэн Х.Жаргалсайханы Хаан банк дахь 5315118466 тоот данс руу шилжүүлсэн байна.

5. Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны дарга Д.Эрдэнэсүх, иргэн Т.Даваадорж нарын 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан дугааргүй ажил гүйцэтгэх гэрээнд Говь-Алтай аймгийн төвд байрлах Гаалийн хорооны конторын барилгын гадна тохижилт, гоёлын төмөр хашаа хийж угсарч, суурилуулах ажлыг 8500.0 мянган төгрөгөөр, 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхээр тусгасан боловч хийхээр төлөвлөсөн ажилд өөрчлөлт орсон тул 5000.0 мянган төгрөг шилжүүлсэн байна.

6. Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны дарга Д.Эрдэнэсүх, "Жигд мод" ХХК-ийн захирал Ц.Ганбаатар нарын 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд Говь-Алтай аймгийн Гаалийн хорооны Цагаан байшинтын боомтын бүсүүдийн зааг тогтоох, хаалт хийх, хашаалах ажлыг 6000.0 мянган

төгрөгөөр, 10 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхээр тусгасан байна. Зөрчлийг шалгалтын-танилцуулгын 7 дугаар хэсэгт дэлгэрэнгүй дурдав.

7. Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны дарга Д.Эрдэнэсүх, "ЭБЗО" ХХК-ийн захирал Н.Бат-Эрдэнэ нарын 2020 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд Говь-Алтай аймгийн Гаалийн хорооны Цагаан байшинтад байрлах 24 өрөө гаалийн ажилтнуудын ахуйн байрыг ариун цэврийн нэгдсэн шугамд холбогдоход шаардлагатай цэвэр бохир усны монтажыг хийж холболтын ажлыг хийж гүйцэтгэх ажлыг 9800.0 мянган төгрөгөөр, 30 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

Улмаар 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр тус ажлыг хүлээн авсан акт үйлдсэн байна.

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт.

2019 онд:

Улсын төсвийн хөрөнгөөр 2019 онд конторын барилгын гадна талыг 30.0 сая төгрөгөөр засварлахаар төсөвт тусгагджээ.

"Үнэлгээний хороо байгуулах тухай" Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны даргын 2019 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн А/07 дугаар бүхий тушаалаар Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны конторын барилгын 2019 онд хийгдэх засвар үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулжээ.

Төсөв захирагч үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд үнэлгээний хорооны даргаар өөрийгөө томилсон байна.

Улсын төсвийн 30.0 сая төгрөгөөр конторын барилгын гадна талд засвар хийхээр 2019 оны 9 дүгээр сарын 26-нд худалдан авах ажиллагаа зарласан боловч нэг ч оролцогч материал ирүүлээгүй тул дахин 2019 оны 10 дугаар сарын 3-ны өдөр зарлаж 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр нээхэд "Орд харш" ХХК материал ирүүлсэн байна.

Үнэлгээний хорооны шийдвэрээр дээрх аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан засварын ажлыг гүйцэтгүүлсэн байна.

Уг гэрээнд гүйцэтгэгч тал ажлыг гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгээгүй тохиолдолд алдангийг хэрхэн яаж тооцох талаар тодорхой тусгаагүй байна.

Техникийн шалгуур үзүүлэлтийн дагуу тус компани нь сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан ирүүлсэн байгаа бөгөөд уг ХХК нь 2017 онд 1998.0 мянган төгрөгийн, 2018 онд 727.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байсан боловч өөр оролцогч ирээгүй гэдэг шалтгаанаар гэрээ байгуулсан байна.

Гэрээнд засварын ажлыг 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хийж гүйцэтгэхээр, захиалагч тал төлбөрийн 90 хувийг 2019 оны 10 дугаар сарын 15-ны өдөр шилжүүлэхээр заасан бөгөөд гэрээний дагуу товлосон хугацаанд төлбөрийг шилжүүлсэн байна.

Гүйцэтгэгч тал гэрээнд заасан хугацаанд тодорхой бус шалтгаанаар /хөрөнгө мөнгө байхгүй/ ажлыг гүйцэтгээгүй учраас захиалагч тал санал гаргаж гэрээний хугацааг 3 сараас сунгаж 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдөр хийж дуусгахаар өөрчлөлт оруулсан байгаа бөгөөд уг хугацаанд гүйцэтгэгч тал ажлаа хийж дуусгасан байна.

"Ажлын хэсэг байгуулах тухай" төсөв захирагчийн 2020 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг засварын ажлыг хүлээн авсан байна.

Гүйцэтгэгч тал ажлаа хийж гүйцэтгээгүй боловч 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нийт төлбөрийн 30% буюу 3.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

2020 онд:

2020 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1-д заасан босго үнээс доогуур үнэ тогтоож иргэн, аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулан ажилласан нь нээлттэй тендер сонгон шалгаруулахаас зайлсхийсэн байж болзошгүй юм.

- Батлагдсан орон тооны мөрдөлт, хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн.

Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/249 дүгээр тушаалын 17 дугаар хавсралтаар тус Гаалийн хорооны зохион байгуулалтын бүтэц, орон тоог 19 орон тоотойгоор баталж, бүтэц орон тоондоо багтаан ажиллаж байна.

- Гаалийн тухай, Төсвийн тухай хууль болон холбогдох журмууд хэрхэн хэрэгжиж байгаа байдалтай танилцаж, тулгарч буй асуудлуудыг дүгнэх, эрсдлээс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг засаж сайжруулах арга хэмжээний санал боловсруулах.

1. Ажлын өдрүүдэд хил дээр болон гаалийн хороон дээр ажилласан ажилтнуудын цагийг /9:00-13:00/-/14:00-18:00/ гэж автоматаар бүртгэсэн тэдийгүй хил дээр амралтын өдөр ажилласан байцаагч болон хороонд ажилласан бусад ажилтнуудад биеэр нөхөж амраах боломжтой байхад цагийн бүртгэлгүйгээр нийт 6238.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон байна.

- Дотоод журам, удирдлагын гаргасан тушаал, гадны байгууллага хүмүүстэй хийсэн гэрээ, хэлцэл нь санхүүгийн хууль, эрх зүйн үндэслэлтэй эсэх.

2019 он:

1. Тайлант хугацаанд */1-12 дугаар саруудад/* төсөв захирагч Засгийн Газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолоор хүчингүй болсон Засгийн Газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Хүн амын бодлого хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 тоот тушаалыг үндэслэн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгосон байна.

2. Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/93 дугаар тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журам мөрдөж ажиллаж байна.

3. Байгууллагын даргын тушаал шийдвэрийг Гаалийн Ерөнхий газрын дэргэдэх хуулийн хэлтэст тухай бүр хянагддаг байна.

ДОЛОО: ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ.

2019 он:

1. Тайлант хугацаанд хүчин төгөлдөр бус эрх зүйн акт үндэслэн төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгосон байгаа нь Засгийн Газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг

2. Конторын барилгын засварын ажил гүйцэтгэгч "Орд харш" ХХК нь ажлаа хийж гүйцэтгээгүй байхад 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нийт төлбөрийн үлдэгдэл 10 хувь буюу 3.0 сая төгрөгийг шилжүүлсэн байгаа нь "Төсвийн тухай "хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт /Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/, "Иргэний тухай" хуулийн 346 дугаар зүйлийн 346.1.дэх заалт /Талууд өөрөөр тохиролцоогүй бол ажлыг бүрэн гүйцэтгэж, ажлын үр дүнг хүлээлгэн өгөх үед хөлс төлнө./-ыг тус тус

3. Тайлант онд урсгал засварын зардлаас нэг бүр нь 230.0 мянган төгрөгийн үнэтэй 2 ширхэг бойлуур, нэг бүр нь 55.0 мянган төгрөгийн үнэтэй 10 ширхэг цонхны хөшиг, нийт 1010.0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авсан боловч байгууллагын хөрөнгөд бүртгээгүй шууд зардалд бичсэн байгаа нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийг тус тус

4. Тайлант онд "Агь нарын овоо" ХХК-иас худалдан авсан 440.6 мянган төгрөгийн үнэ бүхий дэлгэц тооллогоор дутагдаж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 /*Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй*/, 14.2.1 / *Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах/* дэх заалтыг

5. "Алтайн Билэг" холбоонд төрийн өмчийн хөрөнгийг үнэ төлбөргүй ашиглуулж байгаа нь "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хууль болон "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 49 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус зөрчсөн байна.

2020 он:

1. 2020 оны 3, 4 дүгээр сард Бургастайн боомт нээгдээгүй байхад жолоочийн тооцооны хуудсанд хяналт, шалгалт, үйлчилгээ гэж бичин үндэслэлгүйгээр нийт 264.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /*Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/* дэх заалтыг

2. Гаалийн дарга Д.Эрдэнэсүхийн ажилласан хоногийг буруу тооцож 2020 оны 6 дугаар сард 118.5 мянган төгрөгийн цалин илүү тооцож олгосон байгаа нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1/*Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгоно./* дэх заалтыг

3. 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр "Түмэнтуяа" ХХК-ийн 5315654906 тоот харилцах дансанд хамгаалах хэрэгслийн үнэ гэж шилжүүлсэн 5000.0 мянган төгрөгийн анхан шатны баримтаас үзвэл нэг бүр нь 34.0 мянган төгрөгийн үнэтэй 10 ширхэг усны гутал худалдаж авсан байна. Хяналт, шалгалтын хугацаанд тооллого хийхэд өмнө бэлтгэсэн 10 ширхэг усны гутал шинээрээ хадгалагдаж байхад эмийн сангаас дахин 340.0 мянган төгрөгөөр усны гутал бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /*Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах/* дэх заалтыг

4. 2020 онд нягтлан бодогч Д.Жамбалсүрэнд нийт 1670.5 мянган төгрөгийн томилолтын олговрыг анхан шатны баримтын иж бүрдэлгүй буюу буудлын бичиггүйгээр олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 /*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./* дахь заалтыг

5. "Ханбуурал" ХХК-тай гэрээ байгуулж урсгал засварын хөрөнгөнөөс бэлтгэсэн 509.9 мянган төгрөгийн үнэтэй 1 ширхэг сейф, 1200.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн 1 ширхэг буйдан, 560.0 мянган төгрөгийн үнэтэй 1 ширхэг боомтуудын газрыг зураг, нэг метр нь 48.0 мянган төгрөгийн үнэтэй нийт 35 метр шоон хивсэнцэр, нэг метр нь 250.0 мянган төгрөгийн үнэтэй 7 метр улаан хивсэнцэр, нэг бүр нь 159.9 мянган төгрөгийн үнэтэй 6 ширхэг сандал нийт 959.4 мянган төгрөгийн, нийт 6659.3 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг

6. Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхөж үлдэх өртөггүй болсон хэдий ч цаашид ашиглах боломжтой буюу одоо ашиглаж байгаа хөрөнгүүдийг ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоож дахин бүртгэлгүйгээр данс бүртгэлээс хассан байгаа нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 271 дүгээр тогтоолыг

7. Бичиг хэргийн материал, аж ахуйн материал зарлагадахдаа эд хариуцагч өөрийн нэрээр шаардах хуудас бичиж бөөн дүнгээр зарлагадсан, өөрөөр хэлбэл бараа материал хүлээн авсан ажилтан тус бүрээр шаардах хуудас бичүүлж зарлагадаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 /*Анхан шатны бариматад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна./*, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм тус тус зөрчсөн зөрчил илэрлээ.

8. Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны дарга Д.Эрдэнэсүх, "Жигд мод" ХХК-ийн захирал Ц.Ганбаатар нарын 2020 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр

байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнд Говь-Алтай аймгийн Гаалийн хорооны Цагаан байшинтын боомтын бүсүүдийн зааг тогтоох, хаалт хийх, хашаалах ажлыг 6000.0 мянган төгрөгөөр, 10 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхээр тусгасан байна.

"Жигд мод" ХХК нь мод, модон эдлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд Улаанбаатар хотын харъяалалтай компанийг сонгон гэрээ байгуулсан байна. Улмаар 2020 оны 10 дугаар сарын 02-ны өдөр гэрээ дүгнэсэн акт үйлдэж гэрээний үнийн дүнг бүрэн шилжүүлсэн байна.

2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Бургастай дахь шалган нэвтрүүлэх боомтод ажиллах явцад "Жигд мод" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн гэх бүсүүдийн хилийн зааг тогтоох, хаалт хийх, хашаалах ажлыг "Алтайн хүдэр" ХХК хийж гүйцэтгэсэн болохыг олж тогтоосон болно. Улмаар "Алтайн хүдэр" ХХК-ийн холбогдох албан тушаалтантай холбоо барихад тус ажлыг 100 хувь өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн гэж тайлбарласан боловч албан бичгээр өгсөн тайлбартаа тодорхой шалтгааны улмаас энэ талаар тусгаагүй болохыг дурдав.

Улмаар харилцагч байгууллагын үнэ төлбөргүйгээр хийж гүйцэтгэсэн ажилд "Жигд мод" ХХК-тай гэрээ байгуулан үндэслэлгүйгээр 6000.0 мянган төгрөг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /*Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*/, 16 дугаар зүйлийн 16.5.5 /Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах/ дахь заалтуудыг

9. Байгууллагын даргын тушаалаар томилогдсон хөрөнгийн тооллогын комисс хагас болон жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанар муутай хийж гүйцэтгэсэн, санхүүгийн ажилтнууд хөрөнгийг кодолж бүртгэлжүүлээгүй байгаа нь "Төрийн болон орон нутгийн тухай" хуулийг, эд хариуцагч нарын ажлыг хүлээлцүүлэхдээ хөрөнгийг нүд үзэж хүлээлцүүлээгүй, ажил хүлээлцсэн тухай акт үйлдээгүй байгаа зэрэг нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай" 12 дугаар зүйлийн 12.2./Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:/, 12.2.2./эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;/ дах заалтыг тус тус зөрчсөн зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил дутагдалтай холбогдуулан 1163.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 45339.8 мянган төгрөгийн зөрчилд 8 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлэв.

НАЙМ: ДҮГНЭЛТ.

Ажил гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд захиалагч, гүйцэтгэгчийн хүлээх эрх, үүрэг хариуцлагыг тодорхой тусгадаггүй, эдийн засгийн ангилал зөрчиж хөрөнгө бэлтгэдэг, төсөв захирагч тогтвор суурьшилтай ажилладаггүйгээс шалтгаалан дээрх зөрчил дутагдал илэрсэн байна гэж дүгнэж байна.

ЕС: ЦААШДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ.

1. Ур чадварын нэмэгдэл хавтгайруулан олгохгүй байх.

2. Ажилтан, албан хаагчдыг илүү цагаар ажиллуулсан тохиолдолд нөхөж амрах боломж, нөхцлөөр хангаж ажиллах.

3. Өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа тээврийн хэрэгсэлд урсгал засвар хийсэн тохиолдолд авто тээврийн хэрэгслийн ашиглалтын хувийн хэрэгт тэмдэглэл хөтөлж хэвших.

4. 2019, 2020 онд шинээр бэлтгэсэн үндсэн хөрөнгийг бүртгэлжүүлж, кодлох.

5. Ажил гүйцэтгэх гэрээний ажлыг хүлээж авах комиссыг байгууллагын даргын тушаал шийдвэрээр томилох. Гэрээ дүгнэсэн актыг зурган тайлангаар баталгаажуулж хэвших.

6. Ажил гүйцэтгэх гэрээнд ажлын даалгаврыг тодорхой тусгаж, техник, эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцооллыг хавсаргасан байх.

7. Ажил гүйцэтгэх гэрээнд ажлыг гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгээгүй тохиолдолд алданги тооцох тухай заавал тодорхой заалт оруулах

8. Хүчин төгөлдөр эрхзүйн актыг мөрдөж ажиллах

Шалгалтын явцад илэрсэн зөрчлүүдийг цаг алдалгүй арилган, цаашид давтан гаргахгүй байх талаар онцгой анхаарч, шалгалтын танилцуулгаар өгсөн зөвлөмж, улсын байцаагчийн гаргасан захиргааны акт, шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулж, 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд албан бичгээр хариу ирүүлэхийг Говь-Алтай аймгийн Бургастай дахь Гаалийн хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсүх, нягтлан бодогч Д.Жамбалсүрэн нарт хариуцуулав.

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА Д.ГАНЗОРИГ

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Ч.ДУЛМАА

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ Б.ДЭЛГЭРБАЯР